



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2023 СУУРЬ БОЛОВСРОЛ

7
АНГИ

ЭРҮҮЛ МЭНД

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:

САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар бударай.

- Сагсан бөмбөгийн пүүзний онцлогийг сонгоно уу.
 - Шагай гэмтэхээс хамгаалсан түрийтэй.
 - Халтирахаас хамгаалсан резинэн ултай.
 - Шагай гэмтэхээс хамгаалсан түрийгүй.
 - Халтирахаас хамгаалсан хатуу ултай.
- Өвлийн улиралд өмсөх хувцасны хамгийн чухал шаардлагыг сонгоно уу.
 - Хөнгөн, нимгэн, өнгө үзэмж сайтай байх.
 - Дулаан хадгалах чанар сайтай байх.
 - Нэмэлт тоног хэрэгсэлтэй байх.
 - Хүүхдийн анхаарал татахуйц тод өнгөтэй байх.

Нэг удаад хэрэглэж байгаа хүнсний бүтээгдэхүүний хэмжээг хооллох нэгж гэх бөгөөд 80 ккал илчлэгтэй тэнцэнэ.

7-р ангийн сурагч Ж ихэнхдээ дараах байдлаар хооллодог бөгөөд авч буй илчлэгийн хэмжээ 2400 ккал болдог.

Өглөө: 2 ш ёэвэн, 2 зүсэм цөцгийтэй талх, 1 аяга цай

Бага үд: 250 мл газтай ундаа, 1 ш хотдог

Өдөр: 3 ш мантуун бууз, 1 аяга жүүс

Орой: 1 таваг хоёрдугаар хоол, 500 мл газтай ундаа

Дээрх өгөгдлийг ашиглан 3-6 дугаар асуултад хариулна уу.

- Сурагч Ж-ийн өдөрт хоол хүнсээр авч буй илчлэгийн хэмжээг хоолны нэгжээр зөв илэрхийлсэн хувилбарыг сонгоно уу.
 - 25 нэгж
 - 30 нэгж
 - 35 нэгж
 - 40 нэгж
- Сурагж Ж-ийн хоолонд ямар бүлгийн хүнс зонхилж байна вэ?
 - хүнсний ногоо
 - жимс, жимсгэнэ
 - мах, махан бүтээгдэхүүн
 - гурил, гурилан бүтээгдэхүүн
- Сурагч Ж-ийн өдрийн хоолны дэглэмийг сайжруулахын тулд түүнд юу гэж зөвлөх вэ?
 - Өдөрт идэх хоолны хэмжээгээ нэмэх.
 - Хийжүүлсэн ундаа, жүүснээс татгалзах.
 - Сүү, цагаан идээнээс татгалзах.
 - Давсны хэрэглээгээ нэмэх.
- Хоол зүйч сурагч Ж-г А амин дэмийн дутагдалтай байгаа тул А амин дэмээр баялаг хоол хүнс хэрэглэхийг зөвлөв. Ж ямар хүнсийг сонговол оновчтой байх вэ?
 - таксианы мах
 - өндөг
 - вандуй
 - шар лууван
- 6 настай сурагч “Манайхан бүгд утсаа үзээд гэрийн даалгавар хийхэд надад тусалдаггүй, анхаарал тавьдаггүй” гэж хэлжээ. Энэ нь нь түрэмгий харилцааны аль хүчирхийллийн төрөлд хамаарахыг сонгоно уу.
 - сэтгэл санааны дарамт, хүчирхийлэл
 - үл хайхрах хүчирхийлэл
 - бие махбодын хүчирхийлэл
 - бэлгийн хүчирхийлэл

8. Зурагт ямар анхаарал халамж үзүүлж байна вэ?



- A. Найзууд зам хөндлөн гарч байна.
- B. Хүүхдүүдийг зам хөндлөн гаражад тусалж байна.
- C. Машинууд зам дээр зогсож байна.
- D. Өндөр, намаараа цувараад зам хөндлөн гарч байна.

9. Тамхи татдаг хүмүүсийн амьсгалын замын дотор хананы салс ихээр ялгардаг. Энэ нь ямар бодисын нөлөө вэ?

- A. нүүрстөрөгчийн дутуу исэл
- B. никотин
- C. тамхины бохь
- D. нүүрстөрөгчийн давхар исэл

10. Тамхины гоо сайханд үзүүлэх богино болон урт хугацааны үйлчлэлийг зөв харгалзуулсан хэсгийг сонгоно уу.

Богино хугацааны үйлчлэл	A. Шүд шарлана. Б. Шүдний өвчлөл нэмэгдэнэ. В. Усний өнгө цайна. Г. Батга үүснэ.
Урт хугацааны үйлчлэл	

- A. 1-А, В 2-Б, Г
- B. 1-А, Г 2-Б, В
- C. 1-Б, Г 2-А, В
- D. 1-В, Г 2-А, Б

11. Архи, тамхины тухай ойлголтуудаас бурууг нь сонгоно уу.

- A. Тамхи татахад амнаас эвгүй үнэр гардаг.
- B. Архи, тамхины зохист хэрэглээ гэж байхгүй.
- C. Архи элгийг ихээр хордуулж гэмтээнэ.
- D. Тамхийг 1 удаа татахад ямар ч хор нөлөөгүй.

12. Сурагч Эангийн охинтойгоо үерхэж эхэлснээс хойш хичээлээ таслахгүй, илүү шамдан суралцах болж сурлагын дүнд ч ахиц гарав. Энэ үерхлийн үр дүнг оновчтой тайлбарласан хэсгийг сонгоно уу.

- A. Найз охин нь Э-д сайнаар нөлөөлж ээрэг үр дүн гарсан.
- B. Сурагч Э-ийн сурлагын ахиц, амжилт үерхэлтэй холбоогүй.
- C. Найз охинтой байх нь сурлагын амжилтад сөргөөр нөлөөлнө.
- D. Шилжилтийн насанд гарах өөрчлөлтийн нэг нь сурлагын амжилт гаргах юм.


13. Дараах өгөгдлийг уншаад үнэн, худал аль нь болохыг зөв илэрхийлсэн мөрийг сонгоно уу.
/үнэн-Ү үсгээр, худал-Х үсгээр тэмдэглэв/

	Хүчирхийлэгч нь дандаа танихгүй хүмүүс байдаг.	Аль ч хүчирхийлэл гэмт хэрэг мэн.	Ямар ч тохиолдолд хүчирхийлэгчийн буруу.	Хүчирхийлэлд бусдын эрх ашгийг харгалзан үздэг.
A	Ү	X	Ү	Ү
B	X	Ү	Ү	X
C	Ү	X	X	Ү
D	X	X	X	Ү

14. Явган хүний гарцын тэмдэглэгээ аль нь вэ?



15. Зурагт өгөгдсөн туршилтын багаж хэрэгсэлтэй ажиллахдаа аюулгүйн ажиллагааны ямар дүрэм мөрдөх вэ?



- A. Хувцас, арьсан дээрээ дусаахаас сэргийлэх.
- B. Хагалж, гар хөл, арьсаа зүсэхээс сэргийлэх.
- C. Арьсаа зүсэж, гэмтээхээс сэргийлэх.
- D. Түлэгдэхээс сэргийлэх.

Бусад хүмүүсийн тухай өөрийнхөө бодлыг эргэцүүлэн хариултын хуудсанд зааврын дагуу бөглөнө үү.

Доорх зүйлс чамтай хэр тохирч байна вэ?	Би огт тэгдэггүй.	Надтай бага зэрэг адилхан.	Надтай нилээд адилхан.	Би яг тэгдэг.
16. Надад байгаа зүйл хэн нэгэнд байхгүй бол би өрөвддөг.	<input type="radio"/> A	<input type="radio"/> B	<input type="radio"/> C	<input type="radio"/> D
17. Хүмүүс яагаад янз бүрийн үйлдэл гаргадаг вэ гэдгийг би сайн ойлгогдог.	<input type="radio"/> A	<input type="radio"/> B	<input type="radio"/> C	<input type="radio"/> D
18. Хүмүүст хэцүү байгааг хараад би өрөвддөг.	<input type="radio"/> A	<input type="radio"/> B	<input type="radio"/> C	<input type="radio"/> D
19. Би бусдад юм хэлэхээсээ өмнө тэрэнд ямар санагдаж байгаа бол гэж боддог.	<input type="radio"/> A	<input type="radio"/> B	<input type="radio"/> C	<input type="radio"/> D
20. Миний зөв гэдгийг мэдэж байгаа үед бусдын юу гэх надад хамаагүй.	<input type="radio"/> A	<input type="radio"/> B	<input type="radio"/> C	<input type="radio"/> D
21. Би бусдад муухай зүйл хэлэхээсээ өмнө түүнд ямар санагдах бол гэж байнга боддог.	<input type="radio"/> A	<input type="radio"/> B	<input type="radio"/> C	<input type="radio"/> D
22. Би бусдын сэтгэл санаа ямар байгаа бол гэдэгт санаа тавьдаг.	<input type="radio"/> A	<input type="radio"/> B	<input type="radio"/> C	<input type="radio"/> D
23. Би юмыг олон талаас нь бодож үздэг.	<input type="radio"/> A	<input type="radio"/> B	<input type="radio"/> C	<input type="radio"/> D
24. Бусдыг загнаж байгаа хүн муухай харагддаг.	<input type="radio"/> A	<input type="radio"/> B	<input type="radio"/> C	<input type="radio"/> D
25. Бусдад хэцүү байгаа ажилд би санаа тавьдаггүй.	<input type="radio"/> A	<input type="radio"/> B	<input type="radio"/> C	<input type="radio"/> D